



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЭДИЙН ЗАСГИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ



Empowered lives.
Resilient nations.

ЯДУУРАЛ БА МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДЫН МОНИТОРИНГ

ТӨГСГӨЛИЙН ТАЙЛАН

ЯДУУРАЛ БА МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТОГТОЛЦООГ ДЭМЖИХ ТӨСӨЛ MON/05/201

Бэлтгэсэн: Б. Батхишиг (Ph.D), Төслийн богино хугацааны зөвлөх
Хянасан: Саураб Синха (Ph.D), НҮБХХ-ийн ахлах эдийн засагч
П. Цэцгээ, НҮБХХ-ийн хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн

ГАРЧИГ

МОНГОЛ УЛС БА МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД.....	3
ЯДУУРАЛ БА МХЗ-УУДЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТОГТОЛЦОО МОНГОЛ УЛСАД ЯМАР АЧ ХОЛБОГДОЛТОЙ ВЭ?.....	4
МХЗ-УУД БА ЯДУУРЛЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?.....	5
ЯДУУРАЛ, МХЗ-ЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОГТОЛЦООГ ДЭМЖИХ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД 2005-2013 ОНЫ ХООРОНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮР ДҮНГИЙН ТОЙМ ЗУРАГ.....	6
НҮБХХ БА МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ШИНЭ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРАВ.....	7
ТӨСЛИЙН ТОВЧООН.....	7
ТӨСЛИЙН ГОЛ ҮР ДҮН.....	9
1. МХЗ-уудыг хянах иж бүрэн систем бий болгосон.....	10
2. Цахимд суурилсан МХЗ-уудын мэдээллийн сан Монгол улсад бий болсон.....	11
3. МХЗ-уудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг батлав.....	12
4. МХЗ-уудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийн үнэлгээ.....	13
5. Үндэсний иргэний бүртгэлийн нэгдсэн сантай боловсруулсан.....	14
6. Оролцоонд түшиглэсэн ядуурлын мониторингийн аргазүйг ашиглан МХЗ-уудыг хэрэгжүүлэх ажлыг хөдөө орон нутагт гүйцэтгэв.....	16
7. Макро эдийн засгийн нэгдсэн Threshold-21 (T21) загварыг боловсруулсан.....	18
8. МХЗ-уудын хэрэгжилтийн үндэсний илтгэл боловсруулахад оруулсан хувь нэмэр.....	19
9. 2011-2012 онд ядуурлын зураглалыг боловсруулж, хэвлүүлэх ажлыг дэмжсэн.....	22
10. МХЗ-уудыг олон нийтэд сурталчлах ажил.....	23
ТӨСЛИЙН ГОЛ СУРГАМЖ НӨЛӨӨЛӨЛ.....	24
АШИГЛАСАН ХЭВЛЭЛ.....	25

ЯДУУРАЛ БА МХЗ-УУДЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОГТОЛЦОО МОНГОЛ УЛСАД ЯМАР АЧ ХОЛБОГДОЛТОЙ ВЭ?

2004 онд Монгол улсад ядуурлыг хянан шинжлэх систем үндсэндээ үгүй байсан ч уг ажилд ашиглахуйц статистик тоо мэдээлэл хангалттай байсан. Монгол улсын хувьд ядуурлын хяналт шинжилгээ, үнэлгээний тулгамдсан асуудалд тоо мэдээлэл биш харин эдгээр тоо мэдээллийг уялдуулах, хэрэглэх, шийдвэр гаргахад ашиглах зэрэг асуудал багтаж байсан.

2004 оны дөрөвдүгээр сард НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр Ядуурлын Судалгааны Баг (ЯСБ)-ийг Санхүү Эдийн засгийн яамны бүтэц дотор үүсгэн байгуулсан. УИХ-аас баталсан 25-р тогтоолд Монгол улсын онцлогийг тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд эрчимтэй арга хэмжээ авахыг уриалсан ядуурал болон МХЗ-уудыг хянан шинжлэх систем бий болгох үндсийг тавьсан бөгөөд үүнээс улбаалан хэрэгжилтийн механизм бий болгох шаардлага гарсан юм.

2005 онд Монголын онцлогийг тусгасан МХЗ-ыг баталгаажуулснаар, засгийн газар хоёр жил тутам тухайн зорилтын хэрэгжилтийн үйл явцын талаар тайлагнах үүргийг олон улсын өмнө хүлээсэн билээ.

Иймээс МХЗ-уудыг хэрэгжүүлэх зорилгоор төлөвлөсөн арга хэмжээ, хүлээгдэх үр дүнг уг зорилтуудын бодит хэрэгжилттэй уях явдал туйлын чухал бөгөөд энэхүү үйл явцыг хянан шинжлэх, үнэлэх механизмыг идэвхжүүлэх шаардлагатай байсан. Энэхүү чухал зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор НҮБХХ-өөс МХЗ-уудын хэрэгжилт, ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хяналт шинжилгээг сайжруулах зорилгоор Монголын засгийн газарт дэмжлэг үзүүлсэн болно.



МХЗ-УУД БА ЯДУУРЛЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

“Хяналт шинжилгээ”, “үнэлгээ” хэмээх хоёр нэр томъёог янз бүрээр тодорхойлдог ба тэдгээр нь зарим тохиолдолд бие биеэ орлон хэрэглэгдэх боловч үнэн хэрэгтээ гүйцэтгэх үүрэг нь тусдаа юм.

МХЗ-уудын Хяналт Шинжилгээ гэдэг нь Монгол улс есөн зорилго, 24 зорилтуудыг хэрэгжүүлэхэд гарсан дэвшлийг олж тогтоох механизм юм. Энэхүү механизм зорилгуудыг биелүүлэх талаар авч явуулж буй арга хэмжээ, (тухайлбал, бага сургуульд элсэн орох сурагчдын тоо төлөвлөсөн хэмжээндээ хүрсэн эсэх, улаан бурхан өвчний эсрэг дархлаажуулалтад хамрагдах хүүхдийн тоо хэмжээ нэмэгдсэн эсэхийг хэмжих гэх мэт)-биелэгдэж буй эсэхийг хянадаг.

Үнэлгээ гэдэг нь МХЗ-ууд болон ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд авч явуулсан арга хэмжээ тодорхой хугацаанд ямар өөрчлөлт, үр нөлөө гарсныг хэмждэг. Үүний нэг жишээ бол бага сургуулийн үдийн ундны хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн хоол тэжээлийн чанар хэрхэн сайжирсаныг дүгнэх гэх мэт.


Бүх улс орон МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд ашигласан үйлчилгээ, зарцуулсан хөрөнгө, ашиг шимийг хүртэгсдэд гарсан өөрчлөлтийг хянан шинжлэх тогтолцоотой байх шаардлага зүй ёсоор тавигдсан билээ.




Монгол улсын үндэсний хэмжээний МХЗ-ууд нэлээд өвөрмөц онцлогтой, учир нь 9 зорилго, 24 зорилт, 67 үзүүлэлтээс бүрдэх бөгөөд үүнээс Монгол улсын засгийн газрын ард түмэн, иргэний нийгэм, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө авсан амлалт бүрдэж буй юм.



ЯДУУРАЛ, МХЗ-ЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОГЛОЦООГ ДЭМЖИХ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД 2005-2013 ОНЫ ХООРОНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮР ДҮНГИЙН ТОЙМ ЗУРАГ





НҮБХХ БА МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ШИНЭ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРАВ

2005 онд Монгол улсын засгийн газар, НҮБХХ-ийн төлөөлөгчид “Ядуурал ба Мянганы хөгжлийн зорилтуудын хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих” туршилтын төсөлд гарын үсэг зурсан юм.

Уг төсөл дараах үндсэн зорилтыг өмнөө тавьсан болно. Үүнд:

SIGNATURE PAGE		Country: Mongolia
UNDAF Outcome(s)/Indicator(s):	Basic social services are strengthened to provide quality equitable services for all women and men; Good governance that promotes more accountability, transparency and responsiveness is established.	
Expected Outcome(s)/Indicator (s):	The prospects for poverty reduction and equitable development increased through strengthened government capacities to (i) analyze the root causes of poverty, (ii) set economic, fiscal, social and gender policies, and (iii) implement effective policies based on consultations.	
Expected Output(s)/Indicator(s):	As such, the expected results of the project will be: An integrated and decentralized system for coordinating various components of the poverty and MDG monitoring and assessment system is in place; National capacities are strengthened in implementation and outcome monitoring and policy analysis; MDG localization through local-level participatory poverty monitoring initiatives; Domestic and international resources are linked in the framework of MDG; A poverty monitoring information system based on statistical and administrative data is developed and used.	
Implementing Partner:	Ministry of Finance	
Other Partners:	National Statistical Office, Cabinet Secretariat, Academy of Management, National University of Mongolia	
Programme Period: 2002-2006	Programme Component: Achieving the MDGs and reducing human poverty	Budget: USD 1,975,300
Project Title: Pilot Project to Support the National Poverty and MDG Monitoring and Assessment System (PMMS)	Project ID: _____	General Management: USD 98,021
Project Duration: 3 years	Management Arrangement: National Execution-NEX	Support Fee: USD 2,973,331
		Total budget: USD 3,973,331
		Allocated resources:
		• UNDP: TRAC (18/2): USD 500,000
		• Other: USD 75,000
		• In kind contributions: USD 15,000
		• Unfunded: USD 1,400,300
		* Excludes the unfunded budget.
Agreed by:		Date: 22/02/05
	Mr. N. Altankhuyag, Minister of Finance	
		Date: 28/07/05
	Ms. Pratibha Mehta, UNDP Resident Representative	

1) Ядуурлыг бууруулах, МХЗ-уудын биелэлтийг хянан шинжлэх, дүгнэх; нэгдсэн, төвлөрсөн бус, иж бүрэн тогтолцоотой болохыг дэмжих;

2) Хэрэгжилтийг сайжруулах, бодлогын өөрчлөлтийг дэмжихэд хяналт шинжилгээний мэдээллийн хэрэглээ ашиглалтыг сайжруулах

ТӨСЛИЙН ТОВЧООН

Төслийн нэр:	Ядуурал ба Мянганы хөгжлийн зорилтуудын хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих	
Төсөл хэрэгжсэн хугацаа:	2005 оны 4-р сараас 2013 оны 4-р сар хүртэл	
Санхүүжүүлэгч байгууллага:	НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр Солонгос улсын засгийн газар Их Британийн засгийн газар Монгол улсын засгийн газар	
Хэрэгжүүлэгч байгууллага:	2005-2008 2008-2012 2012-2013	Сангийн Яам Үндэсний Хөгжил, Шинэтгэлийн Газар Эдийн Засгийн Хөгжлийн Яам
Үндсэн оролцогч байгууллага:	Үндэсний Статистикийн Газар Улсын Бүртгэл Мэдээллийн Төв	

Энэхүү төсөл нь стратеги төлөвлөлтийг сайжруулах, Засгийн газрын үр дүнд тулгуурласан хяналт шинжилгээний чадавхийг дээшлүүлэх, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль, иргэний нийгмийн бодлогын болон үр дүнгийн шинжилгээ хийх чадавхийг дээшлүүлэх, статистикийн мэдээлэл цуглуулах, түгээх системийг шинэчлэх, ядуурлыг бууруулах, МХЗ-уудын хэрэгжилтийн талаар бодлого боловсруулах, иргэдэд мэдээлэл түгээх зэрэгт шинжилгээ, дүгнэлтийг ашиглах зэргийг тусгасан иж бүрэн төсөл байсан.


Төслийг НҮБХХ, Солонгос улсын засгийн газар, Их Британийн засгийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн болно. Нийт санхүүжилтийн хэмжээ \$ 3,577,217 бөгөөд үүнээс гадна Монгол улсын засгийг газар мөнгөн бус хэлбэрийн хувь нэмэр оруулсан болно.

Санхүүжилтийн төлөвлөгөө ба 2013 оны байдлаар санхүүжүүлэгч талуудын оруулсан хувь нэмрийн хэмжээ (америк \$)

	НҮБХХ	БНСУ-ын Засгийн Газар	Их Британийн Засгийн Газар	Монгол улсын Засгийн Газар	Нийт
Төлөвлөсөн байдлаар	2,279,021	1,101,600	50,000		3,430,621
Төлөвлөсөн мөнгөн бус хувь нэмэр				15,000	15,000
2013.04.30-ний байдлаар оруулсан хувь нэмрийн хэмжээ	2,323,490	1,101,577	41,150	105,000	3,577,217

Төслийн гол зарчмууд:

- ▣ Боломжтой бүх тохиолдолд хяналт шинжилгээ, үнэлгээний хүчин төгөлдөр систем, хамрагдаж буй байгууллагын, сүлжээ, мэдээллийн санд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулах
- ▣ ЯМХЗХШҮТД төслийн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд авч явуулах үр ашигтай арга хэмжээг хэрэгжүүлэхдээ модуляр бүтцийг ашиглах
- ▣ Оролцоонд тулгуурлах. Ядуурлыг бууруулах/МХЗ-уудын үнэлгээний үйл ажиллагаанд иргэний нийгэм, орон нутгийн иргэд гэх мэт аль болох олон талын оролцоог хангахад анхаарлаа хандуулах
- ▣ Ядуурлыг хянан шинжлэх үндэсний чадавхийг төвлөрсөн бус, оролцоог хангасан хяналт шинжилгээний үйл ажиллагаатай ялдуулахад гол үйл ажиллагаагаа чиглүүлэх
- ▣ МХЗ-уудыг хэрэгжүүлэх үндэсний чадавхийг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулах, төслийг хүчин чадлаар нь ашиглах



ТӨСЛИЙН ГОЛ ҮР ДҮН:

1. МХЗ-уудыг хянах иж бүрэн систем бий болгосон нь
2. Вебэд суурилсан Мянганы хөгжлийн зорилгуудын мэдээлийн сан 2007-2008 онд Монгол улсад бий болсон нь
3. УИХ (12-р тогтоол) Мянганы хөгжлийн зорилгуудад суурилсан Үндэсний Хөгжлийн Стратегийг батлав
4. Мянганы хөгжлийн зорилгуудад суурилсан Үндэсний Цогц Бодлогын хэрэгжилтийн үнэлгээ
5. Үндэсний иргэний бүртгэлийн нэгдсэн сантай болов - 2007
6. Оролцоонд түшиглэсэн ядуурлын мониторингийн аргазүйг ашиглан МХЗ-уудыг хэрэгжүүлэх ажлыг хөдөө орон нутагт гүйцэтгэв.
7. Макро эдийн засгийн нэгдсэн Threshold-21 (Т21) загварчлалыг боловсруулсан нь
8. МХЗ-уудын Хэрэгжилтийн Үндэсний Илтгэл боловсруулахад оруулсан хувь нэмэр
9. 2011-2012 онд Ядуурлын зураглалыг боловсруулж, хэвлүүлэх ажлыг дэмжсэн нь
10. МХЗ-уудыг олон нийтэд сурталчилах ажил

ТӨСЛИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



1. МХЗ-уудын хяналт шинжилгээний нэгдсэн тогтолцооны суурь тавигдсан

STATE GREAT HURAL (PARLIAMENT) OF MONGOLIA

RESOLUTION

21st April 2005

No: 25

Ulaanbaatar city

RE: Enforcement of the Millennium Development Goals of Mongolia

Mongolia supports and endorses the Millennium Declaration adopted at the Millennium Summit organized by the United Nations in 2000 and based on the requirement for setting the Millennium Development Goals of Mongolia by 2015 in line with the Millennium Development Goals and for coordinating and organizing their implementation as well as their monitoring and evaluation at national level, the State Great Hural (Parliament) of Mongolia RESOLVES hereby:

1. To endorse the Millennium Development Goals of Mongolia as set in the Annex.
2. To entrust the Government (Cabinet) for undertaking the following actions in connection with organizing implementation of the Millennium Development Goals:
 - 1/ To take actions with regard to reflecting the Millennium Development Goals issues in the Government Program of Action, in the annual Main Guidelines of Socio-Economic Development, as well as in other national development strategy documents to be formulated and adopted from the State hereafter for implementation, and reflecting the costs related to the Millennium Development Goals implementation in the annual State Budgets of Mongolia;
 - 2/ To produce every two years the national reports on the progress status of the Millennium Development Goals implementation and to table it for discussion at the Spring Sessions of the State Great Hural (Parliament);
 - 3/ To ensure participation of the civil society in implementation of the Millennium Development Goals, and to create a partnership between the public sector institutions, non-governmental organizations and the private sector, and to develop their effective mutual cooperation.

As in implementing the Millennium Development Goals alongside with mobilization of local resources to undertake all possible actions to obtain a support of the international banks and financial institutions in providing funds from external sources.

3. To assign the National Statistics Office (P. Byambatsuren) to establish the statistical indicators for measuring the progress towards the Millennium Development Goals in collaboration with the relevant professional organizations, and to create statistical database, and to operate efficiently for provision of information to the relevant organizations.
4. To assign the Standing Committee on State Structure (Su. Batbold), the Standing Committee on Environment, Ch. Bayralsai, the Standing Committee on Economy (T. Damiran), the Standing Committee on Social Policy (S. Lamsaa), and the Standing Committee on Budget (B. Badamdanday) to monitor the enforcement of this Resolution.
5. This Resolution shall come into effect from ...day... month of the year 2005.

(Signature)

УИХ-ын 25-р тогтоол

"Мянганы Тунхаглалыг хүлээн зөвшөөрч, дэмжихийн сацуу МХЗ-уудыг тодорхойлж, хэрэгжилт, хяналт шинжилгээ үнэлгээг үндэсний түвшинд зохицуулахын тулд Монгол улсад хэрэгжүүлэх МХЗ-уудыг тоорхойлох шаардлагатай юм.


Ядуурал ба МХЗ-уудыг хянан шинжлэхийн тулд улс олон даяар үнэн зөв, найдвартай, дэлгэрэнгүй мэдээлэл бүхий хяналтын иж бүрэн систем буй болгохын тулд тууштай арга хэмжээ авах шаардлага урган гарчээ. Төслөөс Монгол улсад МХЗ-уудыг хяналт шинжилгээ, үнэлгээний техникийн ба хүний чадавхийн хүчин зүйлүүдийг сайжруулахад онцгой анхаарал хандуулж ирсэн.

Монгол улсын Үндэсний Статистикийн Газар НҮБХХ-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй Ядуурал ба Мянганы хөгжлийн зорилтуудын хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих төслийг хэрэгжүүлэгч байгууллагын хувьд ядуурал ба МХЗ-уудын хяналт шинжилгээний мэдээллийн системийг буй болгосон.

Энэхүү систем статистикийн болон засаг захиргааны өдөр тутмын мэдээнд тулгуурлан хийгдсэн юм. Үндэсний Статистикийн Газар системийн хэрэглээг хэвшүүлэхийн тулд Ядуурал ба Мянганы хөгжлийн зорилтуудын хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих төслийн хүрээнд цуврал сургалт зохион байгуулж, идэвхтэй ажилласныг тэмдэглэх нь зүйтэй.

Олон улсын хэмжээнд харьцуулалт хийж, зохих түвшинд байгааг баталгаажуулахын тулд Монголын онцлогийг тусгасан нэмэлт Мянганы Хөгжлийн Зорилтыг олон улсын стандарт, НҮБ-ын МХЗ-уудын үзүүлэлттэй уялдуулсан болно. 2009 онд хэвлэгдсэн Монгол улс дахь МХЗ-уудын Хяналт Шинжилгээний Үзүүлэлтийн талаарх гарын авлагад зорилт бүрээр гаргасан үзүүлэлтүүдийн техникийн тодорхойлолтыг эмхэтгэн оруулсан. Энэхүү гарын авлагыг оролцогч тал, сонирхогч байгууллагуудад түгээсэн. Үүний үр дүнд Монгол улс дахь МХЗ-уудын байдлыг бүс нутаг, дэлхийн дундажтай харьцуулах боломжтой болсон юм.

Ядуурал, ДОХ/ХДХВ, хүрээлэн буй орчин, түншлэл, ардчилсан засаглал зэрэг зөрчилдөөнтэй МХЗ-ын зорилгуудын үр дүнг хэмжих шинэ үзүүлэлт бий болголоо. Шинэчилсэн үзүүлэлтүүд болон аргазүйг Үндэсний Статистикийн Газрын тэргүүн 2008 онд баталгаажуулсан юм.



2. Цахимд суурилсан МХЗ-уудын мэдээллийн сан 2007-2008 онд Монгол улсад бий болсон нь

Үндэсний Статистикийн Газар ядуурал болон МХЗ-уудыг хянах мэдээллийн системийг бий болголоо. Энэхүү систем статистикийн болон засаг захиргааны нэгжийн өдөр тутмын тайланд тулгуурласан юм. Уг системд ашиглагдсан үзүүлэлт болон арга зүйг НҮБ-ын МХЗ-уудын үзүүлэлтийн хүрээ ба олон улсын стандарттай нийцүүлсэн болно. Үндэсний Статистикийн Газрын Даргын 2009 оны 01/61 дугаар бүхий МХЗ-уудын Хэрэгжилтийн Хүрээнд гарсан дэвшлийн талаарх тайланг зохицуулах тогтоолд МХЗ-уудтай холботой мэдээлэл цуглуулах, системд оруулах ба DevInfo мэдээллийн санг ашиглах байгууллагуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлсон билээ.

Цахимд суурьтай мэдээллийн сан нь DevInfo 5.0 хувилбарын программ хангамжид тулгуурласан бөгөөд хүний хөгжил, МХЗ-уудын хэрэгжилтэд гарч буй дэвшлүүдийг хянах, хүчин чадал сайтай мэдээллийг нэгтгэж, хадгалж, түгээх чадвартай систем юм. Үүнээс гадна DevInfo бол ширээний компьютер, цахим/вебэд тохируулсан программ бөгөөд англи, франц, орос хэл дээр ажилладаг. Уг систем сурах, ашиглах мэдээлэл дуудахад хялбар. Үр дүнг хүснэгт, график, газрын зураг маягаар гаргаж болно.

Цахимд суурилсан DevInfo систем хэрэглэгчдэд он лайн холбоог ашиглан нэвтрэх эрхийнхээ хүрээнд мэдээлэл сонгож, ашиглах бололцоог олгосон. Үүнээс гадна мэдээлэл оруулсан түүх, цаг хугацаа, хамрах хүрээ оруулж өргөжүүлсэн юм. Үндэсний Статистикийн Газар НҮБХХ-ийн ЯМХЭХШҮТД-ийн төслийн хэрэгжүүлэгчийнхээ зүгээс DevInfo мэдээллийн сангийн хэрэглэгч, администраторуудад зориулан DevInfo 5.0-ын гарын авлага боловсруулан гаргасан билээ. Энэхүү гарын авлага нь төрөл бүрийн хөтөлбөр тухайлбал ядуурлыг бууруулах, МХЗ-ууд-ын хүрээнд шаардагдах мэдээллийн хяналт шинжилгээ, үнэлгээний талаарх хэрэглэгчдийн мэдлэгийг сайжруулах ач холбогдолтой болсон юм.



Онлайн мэдээллийн сан
www.devinfo.mn



Мэдээллийн сангийн жагсаалт

3. УИХ-ын 12-р тогтоолоор МХЗ-уудад суурилсан Үндэсний Хөгжлийн Стратегийг батлав

Монгол улсын засгийн газар улс орны онцлогийг агуулсан хөгжлийн зорилтуудын талаарх урт хугацааны алсын харааг дунд хугацааны стратегитай хамт боловсруулан гаргасан байна.

2008 онд УИХ-аас баталсан 2008-2021 он хүртэлх МХЗ-д суурилсан Үндэсний Хөгжлийн Цогц Бодлогыг боловсруулан гаргахад манай төсөл техникийн туслалцаа үзүүлсэн билээ.



**МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН
ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ
ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО**

**STATE GREAT HURAL (PARLIAMENT) OF MONGOLIA
RESOLUTION**

12 February 2008 No. Ulaanbaatar City

**RE: Endorsement of the Millennium
Development Goals (MDGs)-based
Comprehensive National Development
Strategy of Mongolia**

The State Great Hural (Parliament) of Mongolia RESOLVES hereby:

1. To endorse the Millennium Development Goals (MDGs)-based Comprehensive National Development Strategy of Mongolia as set in the Annex.

2. To entrust the Government of Mongolia (Prime Minister S.Bayar):

1/ To take actions with regard to organizing the implementation of strategic objectives set forth in the Millennium Development Goals-based Comprehensive National Development Strategy of Mongolia, reflecting the in the Government Programme of Action, annual State budget and annual Main Guidelines of Socio-Economic Development, and implementing them;

2/ To elaborate anew or renew National Programmes in line with the Millennium Development Goals-based Comprehensive National Development Strategy of Mongolia, and organize the work on their implementation.

3. To recommend respective Governments in future to take actions with regard to elaborating mid-term policy documents, targeted programmes and projects aimed at implementing the strategic objectives set forth in the Millennium Development Goals-based Comprehensive National Development Strategy of Mongolia, submitting to the State Great Hural for endorsement, reflecting them in the Government Programmes of Action and organizing their implementation.

(signed)

**D.LUNDEEJANTSAN
SPEAKER
STATE GREAT HURAL OF MONGOLIA**

Үндэсний Хөгжлийн Цогц Бодлогын хэрэгжилт хоёр үе шат дамжин биелэх учиртай. Эхний шат 2015 онд МХЗ-уудыг биелүүлж, хүний хөгжлийн индексийг 0.83 болгох зорилтыг хэрэгжүүлснээр дуусах бөгөөд 2021 онд төгсөх хоёрдугаар шатны дуусах үед Монгол улс дундаж орлоготой орнуудын тоонд орсон байх юм.

Энэхүү тайланг дараах сайтаас үзээрэй:

<http://www.un-mongolia.mn/publication/mdg/NDS-eng.pdf>

5. Үндэсний иргэний бүртгэлийн нэгдсэн сантай болов


Иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн системтэй болох үндэсний хөтөлбөрийг баталсан ЗГ-ын 78-р тогтоолоор цаасанд суурилсан архивийн системийг цахим хэлбэрт шилжүүлэх, хүн ам, орон сууц, айл өрхийн бүртгэл, хаягжуулалт, сонгогчдын нэрсийн жагсаалт зэргийн бүртгэлийг шинэчилж, ард иргэдэд хүргэх үйлчилгээг ил тод, үр ашигтай байлгахын тулд орон нутгийн иргэний бүртгэлийн ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэхийг зорьсон юм.


Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын нэгэн хэсэг болгож, 2009 онд НҮБХХ-ийн Төслийн хүрээнд Улсын Иргэний Бүртгэл Мэдээллийн Төвийн иргэний бүртгэлийн иж бүрэн системийн хамралтыг өргөсгөж аймаг, сумдуудыг багтаасан билээ.

Иргэдийн хаягийн компьютерт суурилсан мэдээллийн сан бий болгоход Төслөөс туслалцаа үзүүлсэн бөгөөд үүний үр дүнд иргэд, ялангуяа амьдралын баталгаажих төвшнөөс доогуур амьдралтай иргэд иргэний бүртгэлд хамрагдсах, төрийн үйлчилгээ авах, ажлын байрны зарын дагуу хандах зэрэгт хүндрэл гарахгүй болсон билээ. Үүнээс гадна энэхүү үйл ажиллагаа сонгогчдын нэрсийн жагсаалтыг шинэчлэх ажлын эрчимжүүлж, МХЗ-уудын хэрэгжилтийг хянах үндэс суурийг бүрдүүлсэн юм.



Үндэсний иргэний бүртгэлийн нэгдсэн сангийн нээлтийн ёслолын ажиллагаа, 2009 оны 2-р сарын 13






Ядуурал ба Мянганы хөгжлийн зорилтуудын хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих төслийн хүрээнд Иргэний Бүртгэл Мэдээллийн Улсын Төвийн 21 аймаг, есөн дүүрэг дэх салбарууд төвтэйгөө холбогдож, мэдээлэл цуглуулах, дамжуулах, мэдээллийн баазыг ажиллуулах үйл явц хурдасч, өмнөхөөсөө илүү үр дүнтэй болсон юм.



Хуучин системтэй байх үед аймгаас цуглуулсан мэдээллийг төв рүүгээ явуулахад нэг сар ордог байсан бол одоо электрон сүлжээгээр дамжуулан таваас арван минутын дотор явуулдаг болжээ.

Иргэний бүртгэл мэдээллийн сангийн бүртгэлийн мэдээллийг цуглуулах, шилжүүлэх, хадгалах үйл явц цахим хэлбэрт шилжихээс өмнөх ба дараах дүр зураг



Иргэний Бүртгэл Мэдээллийн Улсын Төв улиралд нэг л удаа иргэний бүртгэл мэдээллийн санг шинэчилдэг байсан бол одоо энэ үйлдлийг хийхэд ганц цаг л ордог болсон байна (доорх зураглалыг харна уу). Домэнийн сервер болон нэгжүүдийг Oracle 10g program ашиглан холбосноор бүх цэгт серверийн мэдээллийг хянах, шинэчлэх боломж бий болсон билээ.

Энэ ажлын үр дүнд засаг захиргааны бүх түвшинд иргэний бүртгэл мэдээллийн сангаас авч хэрэглэх мэдээллийг ашиглах хугацаа, хурд нэмэгдсэнээр холбогдох яамд, засгийн газрын байгууллагуудын төлөвлөлт МХЗ-ын хяналт үнэлгээ сайжирсан.

6. Оролцоонд түшиглэсэн ядуурлын мониторингийн аргазүйг ашиглан МХЗ-уудыг хэрэгжүүлэх ажлыг хөдөө орон нутагт гүйцэтгэв

МХЗ-уудын биелэлтийг эрчимжүүлэхэд орон нутгийн түвшинд тэдгээрийг хэрэгжүүлэх нь нэн чухал бөгөөд үндэсний хэмжээнд боловсруулсан МХЗ-уудыг орон нутгийн онцлогийг тусгасан, орон нутагт хэрэгжихүйц байдлаар боловсруулах шаардлага гарсан. Төслийн хүрээнд үндэсний хэмжээнд баталсан зорилтуудыг орон нутгийн түвшинд буулгаж хөгжлийн бодлого, стратегийг МХЗ-уудтай уялдуулах ажлыг эхлүүлсэн.

Улаанбаатар хотын МХЗ-уудыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 83-р тогтоолоор 2009 онд баталсан. Улаанбаатар хотын онцлогт тохирсон МХЗ-уудыг тодорхойлон өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ дүгнэлт өгөх ажлыг гүйцэтгэж Улаанбаатар хотын МХЗ-уудын биелэлтийг хангах бодлогыг боловсруулсны үндсэн дээр эн тэргүүнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталсан.



Approval of the Ulaanbaatar city MDGs at Citizens Representative Khural of the Capital city

“МХЗ-ыг орон нутагт хэрэгжүүлэхэд чадвар чадамжийг хөгжүүлэх асуудал нэн чухал үүрэгтэй. Орон нутагт МХЗ-уудыг хэрэгжүүлэх явцдаа шаардлагатай чадавхийг бэхжүүлэх дорвитой ажлыг хамтад нь гүйцэтгэж байсан улс орнуудын амжилттай туршлагаас суралцаж болно.”

Эх сурвалж: НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр.2007. МХЗ-ыг орон нутагт хэрэгжүүлснээр орон нутгийн засаг захиргааг үр ашигтай болгох тухай тайлан. http://www.hurilink.org/tools/Localizing_the_MDGs.pdf.




Улаанбаатар хотын Мянганы хөгжлийн зорилтуудын үнэлгээний анхны тайлан 2009 оны 10-р сард төслийн дэмжлэгтэйгээр боловсруулан гаргасан. Энэхүү тайланг нийслэлийн Засаг даргын тамгын газрын хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар болон бусад холбогдох газар хэлтсүүд, Үндэсний хөгжил шинэтгэл хороо, зарим төрийн бус байгууллага, судлаачдын оролцоотойгоор боловсруулан гаргасан. Тайланг бэлтгэх явцад зарим салбарын тоо мэдээлэллийн олдоц, чанар дутагдалтай, дүүрэг, хороодоор гаргасан үзүүлэлтүүд дутуу зэрэг хүчин зүйлс тайланг илүү дэлгэрэнгүй байдлаар боловсруулахад хүндрэл учруулж байсан.

7. Макро эдийн засгийн нэгдсэн "Threshold-21" (T21) загварыг боловсруулсан нь

Монгол улсад макро эдийн засгийн T21 загварыг боловсруулах Үндэсний Хөгжил Шинэтгэлийн Хорооны ирүүлсэн хүсэлтийг НҮБХХ дэмжсэн билээ. АНУ-ад төвтэй Мянганы Институт Монголд гүйцэтгэх зөвлөх ажилд сонгон шалгарч зөвлөх мэргэжилтнүүдээ ирүүлж үндэсний зөвлөхүүдийн хамтаар энэхүү загварыг боловсруулах гэрээнд 2012 оны гуравдугаар сард гарын үсэг зурсан юм. Монгол Америкийн зөвлөх багийнхан есөн сарын хугацаанд T21 загварыг боловсруулсан. Монгол улсын Засгийн газрын Макро эдийн засгийн "T21" загварыг ашиглах тухай 170-р тогтоол 2012 оны 12-р сарын 15-нд гарснаар уг загвар ашиглах эрх зүйн үндэс бий болсон.

Шинээр 2012 онд байгуулагдсан Эдийн Засгийн Хөгжлийн Яам дотроо T21 загвар ажиллуулах мэргэжлийн баг бүрдүүлж энэхүү загварыг олон үйлдэл зорилгоор хэрэглэх шийдвэр гаргасан. Энэ мэргэжлийн баг нь бусад яамдуудад сургалт, зөвлөгөө өгч салбарын бодлого төлөвлөлтөнд T21 загварыг үндэсний хэмжээнд хэрэглэх ажлыг гүйцэтгэх зорилготой болно. Эдийн Засгийн Хөгжлийн Яамны хувьд энэ загварыг Орон нутгийн түвшинд хөгжүүлэх, тохируулан сайжруулах байдлаар орон нутгийн төлөвлөлтийг дэмжих төлөвлөгөөтэй ажиллаж байна.



T21 загвар нь динамик тооцоолол хийх аргачлалд суурилсан тул урт хугацааны хөгжлийн нэгдсэн төлөвлөлт хийхэд тохиромжтой загвар юм. Динамик системийн онолын хүрээнд эдийн засаг, нийгэм, байгаль орчны үзүүлэлтүүдийг нэгтгэн авч үздэг тул онцлог давуу талтай (Мянганы Институт. T21 танилцуулга: Хөгжлийн Нэгдсэн Загвар).

МХЗ-уудын хэрэгжилтийн Үндэсний Гуравдугаар Илтгэлийг боловсруулан гаргахад үзүүлсэн дэмжлэг - 2010

“Улс бүр нийтлэг найман зорилгыг хэрэгжүүлж буй. Гэтэл Монгол улс ес дэх зорилгыг нэмсэн нь сайшаалтай бөгөөд энэхүү зорилгыг улс орон бүр хэрэгжүүлсэн болоосой хэмээх бодол өөрийн эрхгүй төрж байна. Монгол улс олсон амжилтаа Нью Йоркт илтгэх үед энэхүү зорилтын хэрэгжилт хэр чухал болох нь харагдах биз ээ. Монгол улс есөн зорилгын зургааг нь биелүүлэхэд эргэлзэхээргүй болжээ. Энэ улсад зочлох үеэрээ үлдсэн гурван зорилтыг биелүүлэхийн төлөө тэд шаргуу ажиллаж буйг олж харсан. Илүү идэвх чармайлт хэрэгтэй салбар бол яахын аргагүй ядуурлыг бууруулах. Монгол улсад уул уурхайг дагасан асар их хөгжил хаяад ирсэн үед ядуурлыг бууруулах зорилтыг шийдвэрлэх нөөц бололцоо хангалттай гарч ирэх байх. Гэвч энэхүү асуудлыг шийдвэрлэхдээ хөгжлийн бодлого, стратегит тулгуурлах ёстой.” Ажэй Чиббер, 2010 оны 8-р сарын 6.


2010 оны наймдугаар сард Монгол улсын засгийн газар МХЗ-уудын хэрэгжилтийн Гуравдугаар Илтгэлийг боловсруулан гаргасан бөгөөд нийт зорилгуудын 66 хувийн хэрэгжилтийн үйл явц хэвийн бөгөөд 2015 он гэхэд биелэх бүрэн боломжтой хэмээн дүгнэсэн болно.

Өнгөрсөн илтгэлийн хугацаанд 2007-2008 онд МХЗ-уудын хэрэгжилтийн үйл явцад улс орон даяар дэвшил гарсан байна. Гэвч МХЗ-уудын хэрэгжилт төрөл бүрийн түвшин ялангуяа орон нутагт ялгаатай байгаагаас үүдэн орон нутагт тохирох бодлого төлөвлөлт бий болгохын чухлыг харуулав.

Энэхүү илтгэлд есөн зорилгын зургаа нь 24 зорилтын 18 нь хэрэгжих бүрэн боломжтой байгааг дурджээ. Ерөнхий боловсролын түвшинд, 2009 онд бага сургуульд элсэн орогсдын хэмжээ 93.5 хувь, дунд сургуулийнх 91.2 хувь байсан нь томоохон амжилтуудын тоонд зүй ёсоор орсон юм. НҮБ-ын Дэд Ерөнхий Нарийн Бичгийн дарга, НҮБХХ-ийн Ази, Номхон Далайн бүс нутгийн захирал ноён Чиббер Монгол улсын МХЗ-уудын Үндэсний Гуравдугаар Илтгэлийн нээлтийн арга хэмжээн дээр хүндэтгэлийн үг хэлсэн юм. Бангладеш, Вьетнам, Лаосын улсын төлөөлөгчид МХЗ-уудын хэрэгжилтийг хангах, ядуурлыг бууруулах талаар олсон туршлагаа хуваалцахаар энэхүү ёслолын ажиллагаанд оролцлоо.



НҮБ-ын Дэд Ерөнхий Нарийн Бичгийн Дарга, НҮБХХ-ийн Ази Номхон Далайн Бүс Нутгийн Захирал ноён Ажэй Чиббер МХЗ-уудын хэрэгжилтийн Үндэсний Гуравдугаар Илтгэлийг нээх ёслолын ажиллагаанд дээр хүндэтгэлийн үг хэлэх үедээ



МХЗ-уудын хэрэгжилтийн Үндэсний Дөрөвдүгээр Илтгэлийг боловсруулан гаргах үйл ажиллагааг дэмжив - 2012

Монгол улсын засгийн газар МХЗ-уудын хэрэгжилтийн талаарх Үндэсний Дөрөвдүгээр Илтгэлээ боловсруулан 2012 оны зургаадугаар сард албан ёсоор нээлтээ хийсэн юм. Нээлтийн ёслолын үеэр болсон сургалт семинарт Үндэсний Хөгжил Шинэтгэлийн Хорооноос илтгэл тавьлаа.

Илтгэлийг хүргэх семинарт яамдын ажилтнууд, олон улсын байгууллагын төлөөлөгчид, их дээд сургуулийн багш судлаачид, төрийн бус байгууллагынхан оролцсон болно. Илтгэлийг орон нутгийн ба олон улсын байгууллагуудын төлөөлөгчийн газруудад тараасан болно. Уг төслөөс Илтгэлийг англи хэл рүү орчуулах, англи, монгол хэл дээр хэвлүүлэх ажлыг хариуцан хийлээ.



МХЗ-уудын хэрэгжилтийн Үндэсний 4-р илтгэлийн нээлтийн ёслолын ажиллагаа Гадаад хэргийн яамны хурлын зааланд болов. 2012 оны 6-р сарын 12.



“ МХЗ-уудыг хэрэгжүүлэх талаарх Үндэсний Дөрөвдүгээр Илтгэл албан ёсны статистикийн мэдээнд тулгуурласан бөгөөд нэлээд хэдэн буурч буй үзүүлэлтүүд харагдаж байна. Ялангуяа ядуурал болон хүрээлэн буй орчны асуудлууд бүх нийтийн анхаарлыг татахаас өөр аргагүйд хүрчээ. ”

Монгол Улсын ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж

9. 2011–2012 онд Ядуурлын зураглалыг боловсруулж, хэвлүүлэх ажлыг дэмжсэн нь


“Нотолгоонд суурилсан бодлого боловсруулалтыг дэмжих ажлын хүрээнд, НҮБХХ нь статистик эх үүсвэрээс тоо мэдээлэл цуглуулах ажлыг боловсронгуй болгоход үнэтэй хувь нэмэр оруулсан гэж үзэж байна. Ядуурал, МХЗ-ын мэдээлэл орон нутаг, сум дүүргийн түвшинд гарч, ядуу өрхүүдийн тархалтын зураглалыг засаг захиргааны хамгийн бага нэгж хүртэл боловсруулан гаргасан байна.” НҮБХХ-ийн үнэлгээний газар, 2011, НҮБХХ-ийн үр дүнгийн үнэлгээний тайлан.


Монгол улсын Үндэсний Статистикийн Газар ядуурлын үзүүлэлтийг үндэсний ба бүс нутгийн хэмжээнд тодорхойлдог. Гэвч зөвхөн үндэсний болон бүс нутгийн мэдээллийг ашиглах нь үндэсний хөтөлбөрийн зорилтот бүлгийг зөв тодорхойлоход учир дутагдалтай байлаа. Иймээс Төслөөс Үндэсний Статистикийн Газартай амжилттай хамтран ажиллаж, ядуурлын зураглалыг ашиглан аймаг, сумын ядуурлын дэлгэрэнгүй мэдээллийг боловсруулах ажлын зохион байгуулсан билээ.

Ядуурал ба Мянганы хөгжлийн зорилтуудын хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих төслийн дэмжлэгтэйгээр 2000 оны Хүн ам, орон сууцны тооллого, 2002, 2003 оны Хүн амын амьжиргааны түвшний судалгааны дүн дээр тулгуурлан анхны ядуурлын зураглалыг 2009 онд туршилт хэлбэрээр хийсэн болно. Энэ удаа ядуурлын үзүүлэлтийг Хүн ам, орон сууцны 2010 оны толлого, 2011 онды Гэр бүлийн нийгэм эдийн засгийн судалгааг ашиглан хоёр дахь тайлангаа боловсруулан гаргалаа.

Баялгийн ядуурлын үзүүлэлтээс гадна баялгийн бус ядуурлын цогц үзүүлэлтүүд гаргасаны олонхи нь МХЗ-уудтай давхцаж буй юм. Харин Монгол улсын хувьд ихэнхийг нь үндэсний түвшинд тооцоолон гаргажээ. Үндэсний хэмжээний МХЗ-уудын үзүүлэлттэй байна гэдэг чиг хандлагыг хянахад тустай боловч бодлого боловсруулагчид орон нутгийн түвшинд задалсан, илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй байхыг чухалчилдаг билээ. Засаг захиргааны нэгжийн түвшинд гаргасан МХЗ-уудын үзүүлэлтийн дагуу ажиллавал орон нутгийн иргэдэд хүртэц сайтай байх учир баталсан төсвийн хүрээнд ядуурлыг бууруулахад илүү оновчтой байх болно.

“МХЗ-ууд ба Ядуурлын Зураглал-2011” тайланг 2012 оны 11-р сарын 29-нд олны хүртээл болгосон билээ. Энэхүү тайлан ядуурлын бууруулах чиглэлийн төсөл хөтөлбөрүүд, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдын хувьд МХЗ-уудын үзүүлэлтийг үнэлэх МХЗ-уудын хэрэгжилтийн явцыг түргэсгэх зорилго бүхий төсөл боловсруулж хэрэгжүүлэхэд нь чухал гарын авлага болно гэдэгт бид итгэлтэй байна.





10. МХЗ-уудыг олон нийтэд сурталчилах ажил

Ядуурал ба Мянганы хөгжлийн зорилтуудын хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих төсөл засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн улс орон даяар зохион байгуулсан харилцаа холбоо, ухуулан таниулах өргөн хүрээтэй ажилд дэмжлэг үзүүлсэн болно.

Төрөл бүрийн тайлан, ном товхимол, сонин зэрэг ухуулан таниулах материал хэвлэж, нийтийн хүртээл болгов. Үндэсний болон орон нутгийн телевиз, радио ба бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр цуврал баримтат кино, материал цацсан болно.

Энэхүү үйл явцад ард иргэдийг өргөнөөр оролцуулах зорилгоор МХЗ-уудад суурилсан Үндэсний Хөгжлийн Цогц Бодлогыг бэлтгэх үйл явцын талаар тэдэнд мэдээлэл хүргэх сонин гаргах санаачлагыг НҮБХХ дэмжин ажиллав. Уг үйл ажиллагаа бодлого боловсруулагчид, судлаачид, иргэдэд үйл явцыг хянах, санал бодлоо илэрхийлэх боломж олгосон юм.

Жишээлбэл, 2008-2009 онд амжилттай болсон арга хэмжээний нэг бол Үндэсний Хөгжил Шинэтгэлийн Хороо, Монголын Ажил Олгогчдын Холбоо, Ядуурал ба Мянганы хөгжлийн зорилтуудын хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих төслийн хамтран зохион байгуулсан “МХЗ-уудын Ухуулан Сурталчлах Ажил ба Ажил Олгогчийн Үүрэг” сэдэвт зөвлөлдөх уулзалт байлаа.


Эдгээр сургалтын хөтөлбөрүүд МХЗ-уудын орон нутгийн түвшинд хэрэгжилт, МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд ажил олгогчдын үүрэг хариуцлага ба оролцоо, төр хувийн хэвшлийн түншлэл ба хэлбэрүүд, МХЗ-уудын хэрэгжилтийн тэргүүн туршлага зэргийг хэлэлцэх үндэс суурийг бий болгосон талтай. Ийм төрлийн үйл ажиллагааны ачаар хамрагдагсад МХЗ-уудын талаар өргөн мэдээлэл олж авч, хөгжлийн үйл явцад МХЗ-уудын гүйцэтгэх үүргийг ойлгож, хувь нэмрээ оруулж болохуйц арга зам, механизмын талаар санал бодлоо илэрхийлсэн юм.



Монгол Улсын Мянганы Хөгжлийн Зорилтууд: цуврал мэдээлэл, 2007.

ТӨСЛИЙН ГОЛ СУРГАМЖ НӨЛӨӨЛӨЛ:

- ▣ ЯдууралбаМХЗ-уудыг хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих төсөл бол Засгийн газар ба төрийн удирдлагын түвшинд үндэслэл сайтай бодлого боловсруулах чадвар чадамжийг дээшлүүлэхэд чиглэсэн НҮБХХ-ийн үндсэн чиглэлийн биелэлтийн нэгэн томоохон жишээ болсон.
- ▣ Монгол Улсад МХЗ-уудын хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоо хараахан бүрдэж тогтоогүй үед уг төсөл нь дэмжлэг болж орж ирснээрээ Засгийн газрын тухайн салбар дахь чадамжийг бий болгоход хувь нэмэр оруулж чадсан.
- ▣ МХЗ-уудын хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцооны суурийг тавьснаараа үндэсний хамтрагч байгууллагуудын техник болон хүний нөөцийн чадамжийг нэмэгдүүлэхэд уг төсөл нь нөөц бололцоогоо бүрэн дайчлан ажилласан. Удаан хугацаанд Засаг газарт тууштай дэмжлэг болж чадсаны үр дүнд ядуурал болон МХЗ-уудын хяналт шинжилгээ, үнэлгээг явуулах арга аргачлал, шаталсан арга барил процессийг бий болгосон.
- ▣ Уг төслийн хүрээнд аймаг, дүүрэг, орон нутгийн түвшинд МХЗ-уудыг хэрэгжүүлэх зохих туршлагыг хуримтлуулаад зогсохгүй тоон мэдээлэл цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх, хэрэгжилтийг хянах орон нутгийн чадварыг бүрдүүлэхэд дорвитой хувь нэмэр үзүүлсэн.
- ▣ Монгол улс МХЗ-уудыг орон нутгийн түвшинд буулгаж, стратегийн төлөвлөлт, төсөв хуваарилалт, хэрэгжилт, хяналт шинжилгээг системтэй, нэгдсэн байдлаар хийдэг болсон нь МХЗ-ийн хэрэгжилтийг хангах, төр засгийн бодлогыг орон нутгийн хэрэгцээтэй уялдуулах чухал арга хэрэгсэл болсон билээ.
- ▣ Төсөл нь улсын хэмжээнд иргэний цахим бүртгэл, мэдээллийн санг бий болгоход дэмжлэг үзүүлсэн нь улсын хэмжээнд мэдээлэл цуглуулах, мэдээлэл татах, дамжуулах ба хадгалах үйл явцын ил тод байдал болон хурдыг нэмэгдүүлсэн. Энэ ажил Монгол Улсын Засгийн иргэний бүртгэл мэдээллийн тогтолцооны тухай үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан байна.
- ▣ Хөгжлийн цогц бодлого боловсруулах, төлөвлөлт хийх үндэсний чадамжийг бэхжүүлэх ажлын хүрээнд төсөл нь макро эдийн засгийн Т21 загварыг Монголд боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Энэхүү загвар олон салбар хамарсан, олон талт аргачлалд суурилдаг тул яам хоорондын болон салбар дамнасан хамтын ажиллагааг бэхжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулж чадсан.



АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

- Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо. 2011. Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний тайлан.
- Харолд Коуломб, Алтанхүягийн Гэрэлтуяа. 2012. Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлын зураглал – 2011: бүс, аймаг, сүм, дүүргийн түвшний үр дүн
- Монгол улсын Засгийн газар. 2007. Монгол улсын мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт: Үндэсний хоёр дахь илтгэл. Улаанбаатар хот.
- Монгол улсын Засгийн газар. 2009. Монгол улсын мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт: Үндэсний гурав дахь илтгэл. Улаанбаатар хот.
- Монгол улсын Засгийн газар. 2011. Монгол улсын мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт: Үндэсний дөрөв дахь илтгэл. Улаанбаатар хот.
- Мянганы Институт. T21 танилцуулга: Хөгжлийн Нэгдсэн Загвар. <http://www.millennium-institute.org/resources/elibrary/papers/T21Overview.pdf>
- Сангийн Яам, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр. 2007. Монгол Улсын Мянганы Хөгжлийн Зорилтууд: цуврал мэдээлэл. Улаанбаатар хот.
- НҮБ-ын Хүүхдийн Сан. 2009. Guidance Document: Developing and Operationalizing a National Monitoring and Evaluation System for the Protection, Care and Support of Orphans and Vulnerable Children Living in a World with HIV and AIDS.
- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Үнэлгээний Газар. 2011. Үр дүнгийн үнэлгээний тайлан: НҮБХХ-ийн Монгол улсад оруулсан хувь нэмэр.
- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр. 2005. Төслийн баримт бичиг: Ядуурал ба мянганы хөгжлийн зорилтуудын хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих төсөл.
- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр. 2007. МХЗ-ыг орон нутагт хэрэгжүүлснээр орон нутгийн засаг захиргааг үр ашигтай болгох тухай тайлан (Localizing MDGs for Effective Integrated Local Government report).

- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр. 2007. Говь-Алтай Аймгийн Мянганы Хөгжлийн Зорилтууд: Өнөөгийн нөхцөл байдал тулгамдсан асуудлууд.
- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр. 2008. Сонгинохайрхан Дүүргийн Мянганы Хөгжлийн Зорилтууд: Өнөөгийн нөхцөл байдал тулгамдсан асуудлууд.
- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр. 2008. Налайх Дүүргийн Мянганы Хөгжлийн Зорилтууд: Өнөөгийн нөхцөл байдал тулгамдсан асуудлууд.
- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр. 2008. Дорнод Аймгийн Мянганы Хөгжлийн Зорилтууд: Өнөөгийн нөхцөл байдал тулгамдсан асуудлууд.
- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр. 2008. Хөвсгөл Аймгийн Мянганы Хөгжлийн Зорилтууд: Өнөөгийн нөхцөл байдал тулгамдсан асуудлууд.
- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр. 2008. Дундговь Аймгийн Мянганы Хөгжлийн Зорилтууд: Өнөөгийн нөхцөл байдал тулгамдсан асуудлууд.
- НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр. Ядуурал ба мянганы хөгжлийн зорилтуудын хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих төслийг хэрэгжүүлэх нэгж. 2006-2012 оны жилийн тайлан.